

**Монгол Улс**  
**НЭЗХДШ болон ТС-ийг боловсруулах хүрээнд Ховд аймгийн**  
**иргэний нийгмийн байгууллагуудтай хийсэн зөвлөлдөх уулзалт**  
**2017 оны 9-р сарын 20**

*Тус тэмдэглэл нь уулзалтын явцад дэвшүүлсэн асуудлын товч, албан бус тойм юм. Хэрвээ та энэ уулзалтанд оролцсон бөгөөд тэмдэглэлд засвар оруулах эсвэл нэмж мэдээлэл өгөхийг хүсвэл [ibaatarkhuu@worldbank.org](mailto:ibaatarkhuu@worldbank.org) и-мэйл хаягаар Б. Индратай холбогдоно уу.*

Дэлхийн Банк Групп (ДБГ) нь Монгол Улсын хөгжлийн боломж, сорилт, тулгамдсан асуудал болон ДБГ-ээс Монгол Улсад үзүүлж болох дэмжлэгийн талаар санал бодол сонсох, солилцох зорилгоор 2017 оны 9 дугаар сарын 20-нд Ховд аймгийн иргэний нийгмийн 13 байгууллагатай уулзлаа.

Хэлэлцүүлгийг дараах үндсэн гурван асуудлын хүрээнд хийлээ:

- 1) Таны бодлоор Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг хангахад ямар гол боломж, сорилт, бэрхшээл тулгамдаж байна вэ?
- 2) Таны бодлоор дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсын хөгжлийн нэн тэргүүний зорилго юу байх вэ?
- 3) Дараагийн 4-6 жилийн хугацаанд Монгол Улсад ядуурлыг эцэслэж, хамтын хөгжил цэцэглэлтийг тогтвортойгоор хангахын тулд ДБГ (Дэлхийн Банк, ОУСК, ОТХОБА) Монгол Улсад хэрхэн тусалж, дэмжлэг үзүүлэх нь зүйтэй гэж та үзэж байна вэ?

Ангилал	Оролцогчдын санал
<p><b>Улс орны хөгжлийн дүн шинжилгээ (ядуурлыг устгаж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжих арга зам, боломж, сорилт, бэрхшээл)</b></p>	<p><b>Боломж:</b></p> <ul style="list-style-type: none"> <li>• Орон сууцны зээлийн бодлогоос голчлон үүссэн 2011-2013 оны барилгын салбарын өсөлт нь олон ажлын байрыг бий болгож, эдийн засагт хувь нэмэр оруулсан.</li> <li>• Уул уурхайн түүхий эдийн үнэ өссөн нь уул уурхайн салбарын өсөлтөд нөлөөлж, энэ нь улс орны эдийн засагт чухал үүрэг гүйцэтгэсэн.</li> <li>• Өмнө нь хөдөө аж ахуйн салбарын түүхий эдийн үнэ мөн илүү өндөр байснаас ц малчдын гарт илүү их бэлэн мөнгө байхад нөлөөлж, малчид илүү их байшин, орон сууц авч, барилгын салбарын өсөлтөд мөн нэг талаас нөлөөлсөн. Одоо түүхий эдийн үнэ буурч байгаагаас малчид бэлэн мөнгөгүй болж, барилгын салбар ч мөн уруудаж байгааг харж байна.</li> <li>• 2009 оноос хойш цаг уурын нөхцөл байдал таатай байсан нь малын тоо толгой өсөхөд хүргэсэн.</li> <li>• 2009 оноос хойш донор байгууллагууд засгийн газартай хамтын ажиллагаагаа бэхжүүлж эхэлсэн нь улс орны хөгжилд эерэг үр дүнг авчирсан. Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагаа орон нутгийн хөгжилд эерэг өөрчлөлтүүдийг авчирсан.</li> <li>• Манайд ардчилал тогтоод удаагүй, сурч сайжрах зүйл их байгаа бөгөөд ололт амжилт ч гэсэн мөн их байна. Иргэд нэг сонгуулийн үеэс нөгөө рүү илүү ихийг сурч мэдэн, өөрсдийн сонголтыг сайжруулахыг оролдож байна.</li> </ul>

	<ul style="list-style-type: none"><li>• Баруун аймгуудын аялал жуулчлал нэмэгдэж байгаа ба энэ нь Ховд аймагт зарим боломжуудыг нээж байна.</li><li>• Засгийн газраас хэрэгжүүлсэн хөдөлмөр эрхлэлтийн хөтөлбөрүүд нь аймгийн ЖДҮ-дэд ихээхэн дэмжлэг үзүүлсэн.</li></ul>
--	---

## **Сорилтууд:**

### **Засаглал**

- Иргэний боловсрол сул байна. Төрийн үйл ажиллагаан дахь иргэдийн оролцоо, мониторинг хяналт хангалтгүй.
- Засгийн газар хувийн хэвшлийн үйл ажиллагаанд их оролцдог.
- Засгийн газар болон засгийн газрын бодлого тогтворгүй байдаг нь тогтворгүй хөгжил рүү хөтөлдөг. Стратеги, бодлого, хөтөлбөрүүд нэг засгийн газраас нөгөө засгийн газарт үргэлжилдэггүй.
- Эдийн засгийн тогтвортой хөгжил байхгүй байна.
- Төрийн албанд улс төрийн томилгоонууд хийгдэж байгаа нь шаардлага хангахгүй хүмүүс томилогдоход хүргэж байна. Улс төрчдийн төрийн албаны томилгоонд оролцох явдал орон нутагт хүртэл маш их байна. Төрийн албаны чадавх муудсан.
- Олон нийтийн тар засагт итгэх итгэл маш муу байна. Иргэд, олон нийт засгийн газрын зүгээс авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаанд итгэдэггүй учраас өөрсдийн дуу хоолойг өргөж чаддаггүй. Нөгөө талаас төрийн албан хаагчид өөрсдийн ажлыг алдахаас айдаг учраас дарга нарын шийдвэртэй санал нэгддэггүй ч гэсэн тушаалыг нь биелүүлээд явдаг.
- Засгийн газрын бүтэц хэтэрхий томорч, бүхий л салбар, үйл ажиллагаанд оролцдог болсон.
- Төрийн албан хаагчдын биеэ авч явах байдлыг өөрчлөх хэрэгтэй, тэдэнд илүү өндөр шаардлага, шалгуур тавих хэрэгтэй.
- Монгол улсын урт хугацааны хөгжлийн үндэсний хараа, зорилго байхгүй байна. Аж ахуйн нэгж, байгууллага болгон өөрийн алсын хараатай байдаг боловч Монгол улсад байхгүй байна.

### **Бусад:**

- Банкны зээлийн хүү өндөр байгаа боловч үүнээс өөр санхүүжилтийн эх үүсвэр байхгүй тул хүмүүс бэлэн мөнгөний хэрэгцээнээс болж банкны зээлд найдахаас өөр аргагүй байна.
- Ховд аймаг алслагдмал газар зүй байршилтай, мөн мэдээлэл дутмаг байдгаас болж ядуурлын түвшин өндөр байна.
- Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө нэмэгдэж байна, өвөл илүү их хахир хатуу болж, мал ихээр хорогдоход хүргэж байна.
- Аймаг, сумын түвшин мэдээдэл, харилцаа холбооны технологийн асуудлууд их хэвээр байна.
- Салбарын бодлогууд нь улс орны урт хугацааны хөгжлийн ерөнхий зорилго, алсын хараатай нийцээгүй байна. Жишээ нь, боловсролын салбарын бодлого, түүний хэрэгжилт нь Монгол улсын 2030 оны тогтвортой хөгжлийн үзэл баримтлалтай нийцээгүй. Хөдөө аж ахуйн салбар – Ховд аймагт хуучин мах боловсруулах үйлдвэр байсан боловч одоо хаагдсан. Зах зээлд гарах боломж муу, тээврийн зардал өндөр байдаг нь үүний нэг шалтгаан болсон байдаг.

Мөн малчид хоорондоо нийлж, хоршоолол болон ажилдгүйгээс олон боломжийг алддаг.

- Экспортод чиглэсэн ЖДҮ-ийг хөгжүүлж, тэдэнд зээл өгөх хэрэгтэй.
- Хүний хөгжил нь чухал асуудал хэвээр байна.
- Санхүүгийн салбарын бодлогыг тодорхой болгох хэрэгтэй.
- Монгол улсын далайд гарцгүй байрлалаас болж олон бэрхшээл тулгардаг.
- Улс оронд илүү хүчтэй, чадавхтай иргэний нийгмийн байгууллагууд хэрэгтэй байна. ИНБ-уудад чадавх бэхжүүлэх чиглэлээр олон дэмжлэг туслалцаа олгож байсан боловч төдийлөн их өөрчлөлт гараагүй.
- Донор байгууллагуудын дэмжлэгтэй хэрэгжсэн төсөл, сайн туршлагаудыг үргэлжлүүлэн авч үлдэх, хадгалах тал дээр муу ажилладаг.
- Мах болон бусад хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнийг боловсруулах дэвшилтэт технологийг оруулж ирэх хэрэгтэй.

<b>ДБГ-ийн стратеги ба түншлэлийн талаарх санал</b>	<b>Санал:</b> <ul style="list-style-type: none"> <li>ДБГ нь Монгол улсад (i) хөдөө аж ахуй (тэр дундаа мал аж ахуй), (ii) хүний хөгжил, (iii) дэд бүтцийн хөгжил, (iv) засаглал (төрийн албыг бэхжүүлэх), (v) санхүүгийн салбар, (vi) үйлдвэрлэл (жижиг хэмжээний, өрхийн үйлдвэрлэл), (v) ажлын байрхны боломжийг сайжруулах, ажлын байр бий болгоход голлон анхаарч дэмжлэг үзүүлэх нь зүйтэй.</li> </ul>
	<b>Арга зам, хэрэгжилт:</b> <ul style="list-style-type: none"> <li>ДБГ нь төслүүдээ ИНБ-уудаар дамжуулан хэрэгжүүлэх хэрэгтэй.</li> <li>ДБГ нь хүмүүсийн амьжиргаанд сайнаар нөлөөлсөн, сайн үр дүнтэй төслүүдээ үргэлжлүүлэх хэрэгжүүлэх хэрэгтэй. Монгол Улсын эдийн засаг нь Засгийн газраас бүрэн хамаатай байна. Засгийн газар мөнгөтэй, харин хүмүүс, хувийн хэвшил мөнгөгүй байна. ДБГ нь үүнийг тэнцвэржүүлэх тал дээр ажиллах хэрэгтэй.</li> </ul>
<b>Бусад</b>	<ul style="list-style-type: none"> <li>Донор байгууллагуудын хөтөлбөрүүд – хүмүүс донор байгууллагуудын төсөлд илүү их итгэдэг. Донор байгууллагуудын төслийн хүрээнд зарласан тендер шударга зарчмаар, дүрэм журмынхаа дагуу явагддаг бол төрийн тендер эсрэгээрээ байдаг.</li> <li>Дэлхийн Банкны санхүүжилттэй Экспортыг дэмжих төсөл нь сүүлийн үед сонссон хамгийн сайн мэдээ гэдгийг онцлон, Ховд дахь байгууллагууд энэ төслийг маш ихээр сонирхож байгаагаа хэлэв.</li> </ul>

Уулзалтын үеэр оролцогчдоос авсан товч судалгааны хариу:

- Ирэх 10 жилийн хугацаанд ядуурлыг бууруулж, хамтын хөгжил цэцэглэлтийг дэмжихийн тулд Монгол Улс аль чиглэлээр хөгжихөд голлон анхаарах ёстой вэ? (Боломжит хариултуудаас 5 хүртэлх хариултыг сонгоно уу)

— Төрийн удирдлага/шинэтгэл	6	46%
— Ажлын байр бий болгох/хөдөлмөр эрхлэлт	4	31%
— Хөдөө аж ахуй, мал аж ахуй, ойн сан	3	23%
— Эрүүл мэнд	3	23%
— Байгаль орчныг хамгаалах, бохирдлыг хянах	3	23%
— Боловсрол	2	15%
— Авлигатай тэмцэх	2	15%
— Хувийн хэвшлийг хөгжүүлэх	2	15%
— Хөдөөгийн хөгжил	2	15%
— Эдийн засгийн өсөлт	2	15%
— Байгалийн нөөцийн удирдлага	1	8%
— Хүнсний аюулгүй байдал	1	8%

— Нийгмийн хамгаалал	1	8%
— Ус, ариун цэврийн байгууламж	1	8%
— Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөг бууруулах	1	8%
— Гамшгийн эрсдэлийн удирдлага	0	0%
— Эрх тэгш боломжоор хангах	0	0%
— Санхүүгийн зах зээл	0	0%
— Гадаадын хөрөнгө оруулалт	0	0%
— Зам, тээвэр	0	0%
— Худалдаа, экспорт	0	0%
— Хотын хөгжил	0	0%
— Эрчим хүч	0	0%
— Бусад	0	0%

2. Дараагийн 4-6 жилийн хугацаанд ДБГ Монгол Улсыг аль чиглэлд дэмжвэл хамгийн их үр дүнтэй гэж Та үзэж байна вэ? (Боломжит хариултуудаас 3 хүртэлх хариултыг сонгоно уу)

Хүний хөгжлийг дэмжих	4	33%
Бизнесийн орчинг сайжруулах чиглэлээр дэмжих	4	33%
Байгалийн нөөцийн удирдлага, байгаль орчныг хамгаалах чиглэлээр дэмжих	3	25%
Төрийн удирдлага, засаглалын чиглэлээр дэмжих	2	17%
Бүгд чухал	2	17%
Дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг дэмжих	1	8%